



АВИЛГАГҮЙ НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

ЭМГ-ын Эдийн засагч Д.Отгондэлгэр

Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр

2007 он “Авилгатай Тэмцэх Газар” ажиллаж эхэлсэн.

2016 оны 11 сарын 3-ний өдөр

УИХ-ын №51 тогтоол “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр” батлагдсан.

ЗОРИЛГО

- Нийгмийн бүх бүлэг, давхаргад хүрч ҮЙЛЧЛЭХ
- Авлигын эрсдлээс урьдчилан СЭРГИЙЛЭХ
- Олон нийтэд шударга ёсны үзэл санааг ТӨЛӨВШҮҮЛЭХ
- Ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг ХӨГЖҮҮЛЭХ

Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2017-2022 он 6 жилийн хөтөлбөр/

Заалт

•8

Арга хэмжээ

•143

I үе

•2017 он - 2019 он

II үе

•2020 он – 2022 он

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗГ-ын 2017-4-12
өдрийн №114
ТОГТООЛ

- 11 чиглэлээр
- 4 үндэсний хөтөлбөрт тусгагдсан 195 үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ

ЭМГ Үндэсний хөтөлбөрийн хүрээнд

ЭМГ төлөвлөгөө
боловсруулан

- 3 чиглэлээр 14 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан.
- Биелэлт 94%-тай хэрэгжүүлэн ажилласан.

АТГ-аас гаргасан шийдвэрүүд

21 аймаг, 9 дүүрэгт

- 236 зөвлөмж

Эрүүл мэндийн салбарт
/АТГ, ЭМЯ хамтран/

- ЭМСайдын Албан даалгавар-1
- ЭМСайдын Анхааруулга-1
- АТГ-ын Зөвлөмж - 3
- АТГ-аас “Инээмсэглэл бидэнд урам” сарын аян -1

2019 онд АТГ Орхон аймагт



Сургалт болон Өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж нийт 5 байгууллага оролцон ажилласан.

- Байгаль орчин, аялал жуулчлалын газар
- Улсын бүртгэлийн хэлтэс
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- Нийгмийн даатгалын хэлтэс
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар



АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД

110

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/Ярианы төлбөргүй/



1800-1969 дугаарын утас нь энгийн утасны тарифаар ярьдаг байсан бол 110 тусгай дугаар нь үнэ төлбөргүй юм.



АТГ 2019 ОНД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР



2017 оны 07 дугаар сарын 01-ний
өдрөөс хэрэгжиж байгаа “Эрүүгийн
хууль”-д “Авлигын гэмт хэрэг”-ийг
хуульчилсан байдал

- **“Нийтийн албан тушаалтан”**

- Төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч:
- Төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан:
- Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, ерөнхий захирал:
- Төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах, болон гүйцэтгэх ажилтан:
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийг хэлнэ. **Эдгээр албан тушаалтнуудыг тус тус хамааруулан ойлгоно.**

Нийтийн албан тушаалтан албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт



- **“Хамаарал бүхий этгээд”** гэж Нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг хэлнэ.
- **“Нэгдмэл сонирхолтой этгээд”** гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
- **“Авлига”** гэж Албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ.
- **“Ашиг сонирхлын зөрчил”** гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг хэлнэ.

Ашиг сонирхлын зөрчил бичлэг

Хандивтай холбоотойгоор үүссэн ашиг сонирхолын зөрчил


- НАНБХАСЗАСЗУСТХууль 17.4




Нийтийн албан тушаалтан албан
тушаалаас чөлөөлөгдсөний дараах
хязгаарлалт




22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах /3 дахь хэсэг/



22.4 дүгээр зүйл. Хахууль авах /4 дэх хэсэг/




22.5 дугаар зүйл. Хахууль өгөх /2 дахь хэсэг/



- Нийтийн албанд томилогдох эрхийг /2-5/ жил хүртэл хугацаагаар /5,400,000-27,000,000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,
- Эсхүл /1-5 жил/-ээр зорчих эрхийг хязгаарлах,
- Эсхүл /1-5 жил/-ээр хорих ял шийтгэнэ.

22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах /1 дэх хэсэг/




- Нийтийн албанд томилогдох эрхийг гурван жил хүртэл хугацаа /3/-аар хасаж, /5,400,000-27,000,000/- тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,
- Эсхүл /1-5 хүртэл жил/-ээр зорчих эрхийг хязгаарлах,
- Эсхүл /1-5 хүртэл жил/-ээр хорих ял шийтгэнэ.

22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих /1 дэх хэсэг/



22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих /2 дахь хэсэг/



22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах

1.Нийтийн албан тушаалтан

Өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг бусдын нэрийн өмнөөс хэрэгжүүлсэн

Өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг ашигласны улмаас

Бусдын эрх ашигт ноцтой хохирол учирсан /2.5.3 Энэ хуульд заасан “ноцтой хохирол” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсныг ойлгоно./

Нийтийн албанд томилогдох эрхийг хоёр /2/ жил хүртэл хугацаагаар хасаж, /2,700,000-14,000,000/ сая төгрөгөөр торгох

Эсхүл зургаан сараас гурван жил /6 сар-3 жил/ хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах

Эсхүл /6 сар-3 жил/ хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?

- Албан тушаалтан өөрөө болон хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болох эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ.

Хувийн ашиг сонирхол



- Албан тушаалтан хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлоос ангид тэгш шударгаар хэрэгжүүлэхийг хэлнэ.

Нийтийн ашиг сонирхол



- Хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж байгааг хэлнэ.



Ашиг
сонирхлын
зөрчил

Авлига

Албан
тушаалын
гэмт хэрэг

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ НЬ АВЛИГА, АЛБАН
ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ХӨРС СУУРЬ, ШАЛТГААН
БОЛДОГ.

ИЙМД АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ АВЛИГЫН ЗӨРЧИЛ, АЛБАН
ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЧУХАЛ АРГА ЗАМ ЮМ.



8.1.2 дүгээр зүйл. Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах

- 8.1 Албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.
- 8.2 Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, эрх бүхий байгууллага, албан түшаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт /НАНБХАСЗАСЗУСТХ 11 дүгээр зүйл/

11.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ

- өөрийн болон
- өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн
 - Захиргааны шийдвэр гаргах;
 - Удирдах;
 - Хяналт, шалгалт хийх;
 - Хариуцлага хүлээлгэх;
 - Гэрээ байгуулах;
 - Эдгээрийг хэлэлцэх;
 - Бэлтгэх;
 - Оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.



11.2. Албан тушаалтан өөрийн **НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДТЭЙ АШГИЙН ТӨЛӨӨ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХАРИЛЦААГ ДУУСГАВАР БОЛГОСНООС ХОЙШ ХОЁР ЖИЛИЙН ХУГАЦААНД** тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.3. Албан тушаалтан тухайн албан тушаалд **сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол** нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос **ХОЙШ ХОЁР ЖИЛИЙН ХУГАЦААНД** тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны шийдвэр гаргахыг хориглоно.

11.4. Энэ хуулийн 11.3-т заасан захиргааны шийдвэр гаргах хязгаарлалт нь **төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан албан тушаалтанд хамаарахгүй.**

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ: **КЕЙС**

Танай байгууллага тусгай зөвшөөрөл, ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох ажлыг хариуцдаг. Хамт ажилладаг хүн тань зохих шаардлага хангаагүй хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгуулахаар шийдвэрийн төслийг боловсруулж батлуулсан ба уг компаниас шан харамж авсныг та олж мэджээ.

Хамтран ажиллагч тань орон сууцны зээлтэй, гэр бүлийн хүн нь өндөр өртөгтэй эмчилгээ хийлгэдэг, цалингаас өөр орлогын эх үүсвэргүй.



Энэ тохиолдолд та яах вэ?

Дээрх тохиолдол нь ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл мөн үү?

Хариулт:

Авлигын талаар мэдээлэх үүрэг

Авлигын эсрэг хуулиас.

8.1. Албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

Хамтран ажиллагч тань орон сууцны зээлтэй, гэр бүлийн хүн нь өртөг өндөртэй эмчилгээ хийлгэдэг зэрэг нь түүнийг зөвтгөх шалтгаан биш. Тэрээр албан үүргээ гүйцэтгэхдээ албан тушаалаа урвуулан ашиглаж шаардлага хангахгүй, зөрчилтэй этгээдэд тусгай зөвшөөрөл олгож, шан харамж авсан тул энэ үйлдэл нь ашиг сонирхлын зөрчлөөс хальж, албан тушаалын гэмт хэргийн түвшинд хүрсэн байна.

33.1.1.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй этгээдийн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;
33.1.2.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй этгээдэд албан тушаал бууруулах;



2017 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулиар албан тушаалын гэмт хэрэг нь **хэлбэрийн бүрэлдэхүүнтэй** болсон.

Өөрөөр хэлбэл материаллаг хохирол учирсан эсэхийг үл харгалзан, албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн үйлдэл нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдоно.

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ:

Нэгэн төрийн байгууллагын нийтийн албан тушаалтан ажилдаа ирэхдээ 5км зайд явж ирдэг. Тус байгууллагаас 3км зайтай хүүхдүүдийнх нь сургууль болон цэцэрлэг байрлаж албаны машинаар хүргэж өгч орой болгон хүүхдүүдээ авдаг. Нийтийн албан тушаалтан 1 удаа явахад 10км зайг 18км явж ирж буцдаг нь байгууллагад өдөрт 8км шатахууны зардал гарч байна.



- Энэ тохиолдолд та яах вэ?
- Дээрх тохиолдол нь ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл мөн үү?

Хариулт:

НАНБХАСЗАСЗУСТХууль.

6.3. Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.

Нийтийн албан тушаалтан байгууллагын албаны машиныг унаж хувийн хэрэгцээнд ашиглахыг хориглоно. Тухайн байгууллагын албан үүргийн ажилд ашиглана.



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль



ЭРХ ЗҮЙН ОРЧИН



➤ Авлигын эсрэг хууль

/Гуравдугаар бүлэг: 10-14 дүгээр зүйлд ХОМ гаргах, бүртгэх, хадгалах, хянан шалгах, хариуцлага тооцуулах, нийтэд мэдээллэх асуудлыг тусгайлан заасан/

➤ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

/Дөрөвдүгээр бүлэг: 23-26 дугаар зүйлд ХАСМ гаргах, бүртгэх, хадгалах, хянан шалгах асуудлыг тусгайлан заасан, 29 дүгээр зүйлд хариуцлагын асуудлыг заасан/

➤ УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоол,

/Албан тушаалтны ХАСХОМ-ийг бүртгэх, хянах, хадгалах журам, Байгууллага, ЭБАТ-ын эрх үүрэг, мэдүүлгийн маягтуудыг баталсан/

➤ УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014.12.23-ны өдрийн 20 дугаар тогтоол,

/ХАСХОМ гаргах албан тушаалтан, хамрах хүрээ/

➤ УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2017.01.03-ны өдрийн 1 дүгээр тогтоол,

/Баталгааны маягт/

ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

www.iaac.mn

